

Тод үсгээр бичсэн анагаахын сэдэвт дурсгал

*Жалайр Б. Пүрэвсүрэн
З. Мэндсайхан*

Монгол мэргэдийн тод үсгээр бичсэн анагаах ухааны ном судар, орчуулгын бүтээлээс хүмүүсийн гар дээр байсан нь мэр сэр олддог. Харин түүнийг судлах ажил үгүйлэгдэж байна.

Тод үсгээр бичсэн анагаахын томоохон дурсгал гэвэл “Хатгуур төөнийн тод үсгийн дурсгал”, “Хөх хуцын домнолгон оршив”, “Урианхай ардын дом”, “Чингис хааны зарлигт дом”, “Домын гол эмнэлгийн судар”, “Рашааны зүрхэн найман гишүүт нууц удидас оршив”, “Оточ судар”, “Эм найруулах жор” зэрэг чамгүй олон ном байдаг.

Өдгөө болтол уламжилж ирсэн эдгээр мэргэдийн бүтээлд монгол уламжлалт анагаах ухааны эртний түүхэнд холбогдох ховор мэдээ сэлт олон байдгаас нэгээхнийг цухас дурдвал Чингис хаанаас Цагаадай хааны нэр дээр илгээсэн зарлигийн тухай бичсэн бүрэн эхийг дурдаж болно.

Бидний нийтлүүлж байгаа энэ тод үсгийн дурсгал /018, 019, 020-р зүйл/-д байгаа гаднаас авч хэрэгдэсэн эм, эмчилгээний арга нь Чингис хаан зөвхөн цэргийн хүрээний эмнэлэгт төдийгүй монгол уламжлалт анагаах ухаанд гадаад улс орноос эмнэлгийн сайн арга туршилгыг авч хэрэглэх санаа тавиж гаргасан нь зөвхөн Цагаадайд хандсан бус харин бусад бага хааддаа адил хандсан байж болохыг давхар нотлож байна.

Уул зарлиг бол эмнэлгийн талаар гаргасан хааны зарлиг гэдгээрээ бус уламжлалт монгол анагаах ухаан, түүний дотор цэргийн эмнэлгийн хүрээнд гэмтэл, бэртлийг тархинд мэс засал хийх хэмжээнд хүртэл олон шинэ аргаар баяжуулсан түүхэн ач холбогдолтой болох нь илэрхий байдаг.

Бас зохиогч гарсан он цаг нь тодорхойгүй, 17х21 см цаасан дээр хар бэхээр бичсэн тод үсгийн 8 хуудас /14тал/ хэмжээтэй эхлэл төгсгөлөөсөө дутуу нэг номыг бид 1989 онд олж билээ. Энн номонд цэрэг дайны үеийн шархтанд эмнэлгийн тусламж үзүүлэх, гэмтэл бэртлийг анагаах 29 зүйлийн арга домыг бичсэн байлаа. Энэ тухай бид /Б. Пүрэвсүрэн, З. Мэндсайхан/ 1989 онд “Улаан од” сонинд товч мэдээ бичсэн буй.

Энэ удаад бид түүнийг судлахад дөхөм болгож эм домын арга тус бүрийн өмнө дугаарлаж сударт байгаа дарааллаар нь дахин буулгаж бичлээ. Үүнд:

001. Донрой нэг лан, жумз нэг лан, эдгээрийг нарийн талхлаж сайн исэглэнд зуураад ярыг урьдаар сайтар хусаж цус гаргаад дахин дахин түрхвээс хог үгүй эдгэмүй. Энэ болбоос хуучин шинэ алив илт, бус хамууг магад эдгээх бөгөөд миний бие олон онд гарт авч мэдсэн дээд бөлгөө.
002. Дүгрэг үлдэнд хар байванг түлээд гахайн цусанд зуурч түрхвээс эдгэмүй.
003. Нэг зүйл алив мэсний шарханд хийгээд яс мах гэмтсэн бүгдэд түргэн туслах эм нь : сайн мөөг 070, түлсэн байван 015, түүхий байван 015 – ыг нарийн талхлаж мэсний шарханд түрхвээс даруй эдгэмүй.
004. Бэрх цус эс зогсвоос жил удсан шохой буюу эсвээс бэншайн талх шавбаас даруй зогсож хялбар бүтмүй.
005. Алив шархны цус ба өвчнийг зогсооход сонгинын цагаан шилбэ бяцалж цагаан чихэр хольж дахин дахин шавбаас цус, өвчин зогсож сорвигүй эдгэх гүн увидас бөлгөө.
006. Хар чихэр чанаж хэтүүг түрхвээс сайн.
007. Цохигдсон нь хөхөрч хавдраас жүр үрийн талхыг түүхий гурил лугаа нухаж түрхвээс даруй амирламой. Эсвээс жумзыг гаагийн шүүсэнд зуурч түрхвээс хавдар харимуй.
008. Мэсний шарханд чавга нухаж шавшваас маш сайн. Эсвээс мөөг нэг цэнг, хүйтэн усанд бяцхан номхотгосон сувд 050 хольж нарийн талхлаж шавбаас даруй эдгэх ЦЭРГИЙН ХҮРЭЭНИЙ НУУЦ УВИДАС бөлгөө.
009. /Мэсний шарханд/ эсвэл егүүшин зажилж түрхвээс мөн адил бөлгөө. /Даруй эдгээр цэргийн хүрээний нууц увидас бөлгөө/
010. Цавчирган ташуурын шарханд түүхий жумз 010, мангавура 050, бал лугаа зуурч шавбаас өвчин даруй зогсмуй. Хэрэв өдөр удтал эс эдгэвээс эр гахайн ноос буюу чөмөг сайн.
011. Хэрэв бэрх цавчигдаж зүрхэнд цус үсэрч үхэтхийвээс суму 030, гүргүм 030, дангүний үндэс 030, нарийн талхласныг хүүхдийн шээс буюу архинд чанаж цутгаваас сэхээрмүй.
012. Гиван 004, хүхэр 100 талхлаж таар саванд хийж давстай шавраар бөх сайн таглаж хатаагаад морин цагаас маргаата /маргааш/ наран гартал нүүрсний галд түлээд талхлаж хэрэглэх цагт эмийн халбагаар гурвыг архинд хүүхдийн шээс хольж чанаад халуун уулгаваас тус чадал нь мэсний шарх хийгээд унасан цохигдсон, морь мал өшиглөсөн тэргүүтнээр харгаж үхэтхийхэд исгэсэнд энэ эмийг ууснаас амьдарч өвчин зогсмуй. Цул савд тогтсон ба нөжирсөн цус хальж ус болон бөөлжих буюу эсвээс дорогши гармуй. Доргиовоос нөжирсөн цус хайлж хавдар харьж өвчин зогсмуй.
013. Шөрмөс холбирч яс гэмтээд тэсэшгүй өвдөөс хулганын хорголыг нь түлээд гахайн өөхөнд зуурч шаваад боовоос даруй зогсмой.
014. Эсвээс юнгарын талхыг халуун усаар зуурч түрхвээс бас өвчин зогсмуй.
015. Хугарсан ясыг залгах чухал эм нь бойгар 025, гүгүл 025, лардуу 050, гиван 100, луугийн яс 015, 015 нарийн талхлаж сайн исэглэнд чанаж хатмагц талхлаж бүлээн архиар 010-ийг даруулж уумуй. Яс магад залгамуй. Яс нэгтэй залгавал луугийн ясыг хасмуй.

016. Улаан зэсийн тан нарийн талхыг 005-г архиар даруулж ууваас хугарсан газарт шууд хүрч гагнамуй. Урьд нэг хүн мориноос унаад хөл нь хугарсанд улаан зэсийн талхыг архиар ууж эдгээд хожим үхсэн хойно арван хэдэн жил болоод ясыг үзвээс хугарсан газар бодтой гагнагдсан зэсийн бал буйг нүдээр үзвээ.
017. Чилисан хэмээх эмийн найрлага нь: цалгод 012, заар 0025, ли шилгавар 0025, бойгар 015, гүгүл 015, хач гүргүм 015, дожа 024, матрын цус 100 эднийг таван сарын шинийн тавны морин цагт нийлүүлэн маш нарийн талхлаж шил буюу шаазан лонхонд хийж эмийг гиван лахаар бөглөж хүч үнэрий нь бүү гарга. Хэрэглэхэд хэрэв шинийн таван эс тохиолдвоос тэнгэрийн эрдэмт тэнгэр, сайн эрдэмт тэнгэрийн өдөр найруулбал болмуй. Бачимдваас /яарваас/ мөн цагт найруулж бас болмуй. Үүний тул чадал нь мэсний шарх, ухасан цохигдсон, яс хугарсан шөрмөс тасарсан, цус эс тогтсон бүхэнд долоон ли архиар уумуй.
018. /чилисанг/ шарханд архинд зуурч түрх. Мэсний шарх, хүнд хоолой огтолсонд түүнийг хуурай сацваас өвчин цус зогсмуй. Мөн цагт тусламуй. Энэ нь ЦЭРГИЙН ХҮРЭЭНИЙ ГҮН УВИДАС бөлгөө.
019. Бойгар, гүгүл, зээргэнэ, көшилиг хувь тэгш нарийн талхлаж алив хүнд хөнгөн шарх, унасан цохигдсон тэргүүтэнд архиар 010 хиртэйг уулгаад шарханд архинд зуурч түрхвэл өвчин зогсоогчийн манлай бөлгөө. Энд бол угтаа хүй сайн найрлага буй. Үүнийг өдгөө “Дөрвөн баатар” хэмээн нэрийджээ. Яр хорхойшоод мах бүтэлдэхгүй болбоос нэг цэн шохойн дээр найман цэн усанд хийж дахин дахин сайн хутгаж зогсоогоод тунасан усыг саванд авч шохойг зуурч ярын их бага хэмжээгээр цагаан даавууг хайчилж аваад шохойн усанд дэвтээж ярын дээр нааж хатмагц шинийг дахин дахин сольж нааваас хорхой нь үхэж мах ургах тул мах ургуулах эм хийвээс түргэн бүтэлдэж эдгэмүй. Энэ болбоос ШИ ШАН ЖУ ЯН газраас уламжилсан НУУЦ УВИДАС бөлгөө.
020. Нэг зүйл алив мах ургуулах эм нь: бойгар 030, гүгүл 030, матрын цус 030, дожа 030, шилгавар 010, нарийн талхлаж яранд цацваас даруй ярын ам ургаагүй мах ургаж бүтэх болмуй.
021. Дожа 010, цалгар 005, баргилд 005, шилгавар 5 ли, луугийн яс 010 нарийн талхлаж ярыг /шархыг/ урьдаар цайгаар угаагаад өчүүхнээр цацваас даруй мах ургаж эдгэмүй.
022. Луугийн яс 010, далайн хөөс 010, байгар 010, гүгүл 010, зааны арьс 010, шилгавар 003, сувд 008, нарийн талхлаж цацваас мах ургаж даруй бүтэлдмүй. Эдгээр эмүүд нь маш нарийн талхлаж шил буюу шаазан лонхон дотор хийж гиван лах зүйлээр сайтар бөглөж хүч ба үнэрийг эс гаргаваас маш сайн.
023. Шархны цус нөжирч өвдөөс жумзын талхыг гаагийн шүүсэнд зуурч түрхвээс нэг хоног хүрэнтэж хоёр хоногт цаймуй.
024. Нэг зүйл алив нохой, могой тэргүүтэн зуусан хатгасан шарханд түргэн туслах эм нь: Нохой зууж шарх гарсан эс гарсанд нохойн хатсан аргалыг голомтноос зайс /хол/ түлээд нүүрс болгоод газарт булж галын хорыг гаргаж нарийн талхла дэлийн /ургамал/ тосонд зуурч түрхвээс цаг даруй /дорхноо/ өвчин нь зогсож хэдэн хоногтоо эдгэмүй.
025. Бас /ноцсон шарх/-нд хүнцэл “нэг мянгантаа алхсан” хэмээх иргэн доторхи шороо хоёуланг хуураад чанасан усаар 020 донрой даруулан ууж хөлөрвөөс эдгэмүй.
026. Галзуу нохой зууваас долоон жант /улаан цоохор хорхой/-ын сүүл жигүүрий нь аваад тахианы өндгөн дотор хийж чанаад жантыг хаяж өндгийг идвээс шээс лүгээ

цус нөж гармуй. Чанаж эс идвэл хорт цус нь гарч дуусаагүй тул дахин урьд адил хийж идэж цус гарч дуусваас даруй хор нь амирлаж галзуурахгүй болмуй. Эсвээс мөнхүү сүүл толгой жигүүрий нь авсан долоон жантайг нумай тутарга лугаа шаралтал хуураад тутаргыг зууран талхлаж архи ус хоёрыг тэгш хольж чанаад даруулж цатгалан дээр ууваас шээс лүгээ нөжирсөн цус гарч шээсэн газарт удваас гөлөгний дүрс гармуй. Шээс цэвэр болмогц хор нь амирламуй. Зуу хоног болтол хэнгэрэг харангын дуу сонсох ба нохой гахай тахианы мах загасны мах, сонгино идэх архи уухыг цээрлэнэ. Осолдвоос урвах бөлгөө. Түүхий жунз 050, гива 030, хатсан хүр хорхой долоог нэмвээс нэн эрхэм бөлгөө.

027. Могой хатгаваас бэүзэйн / / талх хий. Майтунгийн шүүсээр даруулж өгвөөс эдгэмүй.

028. Дигваранз хатгаваас худгийн ёроолын /хуудас дутуу болжээ./

Тод үсгийн энэ дурсгалд цэргийн эмнэлгийн зориулалтаар нууцалсан 008, 019, 020-р зүйлд үзнэ үү. Эртний нангиад чилисан хэмээх эмийн найрлагыг /018-р зүйл/ цалгод, заар, шилгабур, бойгар, гүгүл, хач гүргүм, дожа, матрын цус гэсэн найман орцтой байхаар бичсэн байхад 1922 онд Өргөө хотын маарамба Чойжамцын бичсэн “Онцар гадан дэр зод” гэдэг төвд сударт дод зэ, балжав, давсан хавлин, бойгар, жуган гэсэн зургаан орцтой найруулахаар бичсэн байна. Үүнээс үзэхэд бойгараас бусад орц нь бүрэн өөрчлөгдсөн шинэ жор болсон байна. Энэ бол монгол эмч мэргэд хятад, төвд, энэтхэгээс уламжилсан эмийн жорыг өөрийн орны өвөрмөц онцлогт нийцүүлэн аль боломжтой тохирох адил үйлчилгээтэй бодисоор орлуулж сайжруулсан шинэ эм гаргаж авдаг байсны нэг тод жишээ юм.

Энэ тод үсгийн дурсагл дахь эм эмчилгээний аргыг нарийвчлан судлахад нутгийн үг аялгуу, манж, төвд, хятад нэрийн тайлбар, зарим газар орны нэрийг тодлон лавшруулж судлах нь чухал.

Ном зүй

1. Пүрэвсүрэн, З. Мэндсайхан Цэргийн хүрээний эмнэлгийн нууц увидас. “Улаан од” сонин 1989 он.
2. Ц. Шагдарсүрэн Монголчуудын хүн эмнэлгийн уламжлал “Монголчуудын утга соёлын товчоон” Улаанбаатар 2003.
3. Чингис хааны зарлигаар Цагаадай хааны илгээсэн дом. /тод үсгийн гар бичмэл /
4. Урианхай нутгийн дом / тод үсгийн гар бичмэл /
5. Чойжамц онцар гадан дэр зод / төвд судар 1922 он /

[illegible][illegible]

[illegible][illegible][illegible]

[illegible][illegible]

此道元氣為本，氣為神之主，神為氣之使。氣清則神清，神清則氣清。氣濁則神濁，神濁則氣濁。此道元氣為本，氣為神之主，神為氣之使。氣清則神清，神清則氣清。氣濁則神濁，神濁則氣濁。

此道元氣為本，氣為神之主，神為氣之使。氣清則神清，神清則氣清。氣濁則神濁，神濁則氣濁。此道元氣為本，氣為神之主，神為氣之使。氣清則神清，神清則氣清。氣濁則神濁，神濁則氣濁。

此道元氣為本，氣為神之主，神為氣之使。氣清則神清，神清則氣清。氣濁則神濁，神濁則氣濁。此道元氣為本，氣為神之主，神為氣之使。氣清則神清，神清則氣清。氣濁則神濁，神濁則氣濁。

此道元氣為本，氣為神之主，神為氣之使。氣清則神清，神清則氣清。氣濁則神濁，神濁則氣濁。此道元氣為本，氣為神之主，神為氣之使。氣清則神清，神清則氣清。氣濁則神濁，神濁則氣濁。